



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУНААЛ

2018 11 16

252

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2,  
Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг тус  
тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч  
бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийн  
бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх ажлын удирдамжийг  
хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Ажлын хэсэг усан замын тээврийн хэрэгслийн жолооч, холбогдох  
хүмүүсийн оролцоотой ажил, мэргэжлийн дүн шинжилгээ хийхтэй холбогдон  
гараах зардлыг зохих эх үүсвэрээс гаргахыг Далайн захиргаа УТҮГ  
/С.Түвшинтөр/-т даалгасугай.
3. Удирдамжид заасан ажлын явц, чанарт хяналт тавьж тус журам,  
сургалтын хөтөлбөрийг 2019 оны II улиралд багтаан батлуулахыг Төмөр  
зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын  
үүргийг түр орлон гүйцэтгэгч/А.Батболд/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг  
Хяналт–шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч /М.Энхболд/-д даалгасугай.

САЙД *Б.Содбаясгалуу.СОДБААТАР*

080655

Зам тээврийн хөгжлийн сайдын  
2018 оны // дугаар сарын **6** ны өдрийн  
**252** дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн  
ахлагч:

Д.Жавхлан

Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн  
дарга

Гишүүд:

Д.Ганбаатар

Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн  
ахлах мэргэжилтэн,

Ж.Цэцэгжаргал

Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газрын Мэргэжлийн  
боловсрол болон мэргэжлийн сургалтын стандарт,  
агуулга, арга зүй хариуцсан мэргэжилтэн,  
/зөвшилцсөнөөр/

Д.Эрдэнэбат

Мэргэжлийн сургалтын бүртгэл, гэрчилгээжүүлэлт  
хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Б.Нэргүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын  
газрын усан замын асуудал хариуцсан  
мэргэжилтэн, усан замын тээврийн хяналтын  
улсын байцаагч

Б.Амартувшин

“Далайн захиргаа” УТҮГ-ын захиргаа, удирдлагын  
хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/

Т.Олонбаяр

“Далайн захиргаа” УТҮГ-ын усан замын асуудал  
хариуцсан ажилтан, усан замын тээврийн  
хяналтын улсын байцаагч /зөвшилцсөнөөр/

Ш.Энхбаяр

“Далайн захиргаа” УТҮГ-ын усан замын асуудал  
хариуцсан ажилтан /зөвшилцсөнөөр/

~оOо~

Зам тээврийн хөгжлийн сайдын  
2018 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн  
252. дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

"Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам,  
сургалтын хөтөлбөр" боловсруулах ажлын хэсгийн  
удирдамж

1. Ажил мэргэжлийн лавлах боловсруулах
2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, холбогдох хүмүүсийн оролцоотой ажил, мэргэжлийн дүн шинжилгээ хийх /DACUM/
3. "Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам"-ыг Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам"-тай уялдуулан боловсруулах,
4. "Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр"-ийг "MNS 6541 2015. Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага" стандартын дагуу чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт нийцүүлэн боловсруулах,

~oOo~